ЧАНАР - БИДНИЙ ЗОРИЛТ

СТАНДАРТ, ХЭМЖИЛЗҮЙ

СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗРЫН ХЭВЛЭЛ /2021 ОН ТУСГАЙ ДУГААР/

ИЛҮҮ САЙХАН ДЭЛХИЙН ТӨЛӨӨ ХАМТЫН ЗОРИЛГО

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТЫН СТАНДАРТУУД

ДЭЛХИЙН СТАНДАРТЫН ӨДӨР

2021 оны 10 дугаар сарын 14

ЧАНАР - БИДНИЙ ЗОРИЛТ

СТАНДАРТ, ХЭМЖИЛЗҮЙ

СЭТГҮҮЛИЙН РЕДАКЦИЙН ЗӨВЛӨЛ

Сэтгүүлийн эрхлэгч: Б.Эрдэнэзул

Нарийн бичгийн дарга: Д.Пүрэвсүрэн

Гишүүд: Д.Бэхбат
Г.Батзориг
З.Мөнхбат
Д.Өнөрбилэг
Б.Ууганбаяр

Техник редактор: Б.Дөлгөөнбаяр

© Энэхүү сэтгүүл нь Монгол Улсын Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хуулиар хамгаалагдсан болно.

Сэтгүүлийн захиалга:
“Монгол шуудан” ТӨХК Индекс – 200325

Сэтгүүлийн гаралт:
Улирал тутам

www.masm.gov.mn

СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗАР

Энхтайваны гудамж – 46а
Улаанбаатар хот 13343
Утас: 976–51–263971
Факс: 976–51–261631
E–mail: standard@masm.gov.mn
press@masm.gov.mn
www.masm.gov.mn

Мөнхийн Үсэг ХХК–д хэвлэв.

АГУУЛГА

МЭНДЧИЛГЭЭ

- Монгол Улсын Шадар сайдын мэндчилгээ
- Стандарт, хэмжил зүйн газрын даргын мэндчилгээ
- Илүү сайхан дэлхийн төлөө хамтын зорилго

ЦАГ ҮЕ

- Олон улсын цахилгаан техникийн хорооны 85 дугаар ерөнхий чуулган боллоо
- “Ирээдүй хэдийнэ эхэлчихсэн” уриан дор ISO week зохион байгууллаа

ТАНИН МЭДЭХҮЙ

- Ковид ба стандарт
- Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын менежмент. Ковид цар тахлын үед аюулгүй ажиллах ерөнхий зааварчилгаа
- Уур амьсгалын өөрчлөлтөнд текстилийн салбарын үзүүлэх нөлөө
- MNS 6891; 2020 стандарт “Хариуцлагатай нүүдэлчин зохистой дадлыг нэвтрүүлэхэд тавих шаардлага”

МЭДЭЭ МЭДЭЭЛЭЛ

- Жуулчны мэдээллийн төвийг олон улсын түвшинд хүргэх боломж бүрдлээ
- Хүнсний ногооны стандартууд шинэчлэгдлээ
- “Кейтеринг үйлчилгээнд тавих шаардлага” стандартыг хэрэгжүүлж эхэллээ
- Чип бүхий төлбөрийн картыг зайнаас унших боломжтой
- Үсчний үйлчилгээнд тавих нэмэлт шаардлага

www.facebook.com/Стандарт, хэмжил зүйн газар
www.youtube.com/ Стандарт, хэмжил зүйн газар
www.masm.gov.mn/TV Стандарт, хэмжил зүйн газрын цахим телевиз

МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙДЫН

МЭНДЧИЛГЭЭ

Монгол Улсын “Стандартчилал, Хэмжил зүйн ажилтны өдөр” болон “Дэлхийн стандартын өдөр”-ийг тохиолдуулан салбарын нийт албан хаагчид болон стандартчилал, хэмжлийн нэгдмэл байдлыг эрхэмлэгч хэн бүхэнд Засгийн газрын нэрийн өмнөөс болон хувиасаа чин сэтгэлийн халуун мэндчилгээ дэвшүүлье.

Цар тахлын хүнд үетэй дэлхий нийтээрээ нүүр тулж буй энэ цаг үед нийгмийн тэгш бус байдлыг арилгах, эдийн засгийн тогтвортой хөгжлийг нэмэгдүүлэх, уур амьсгалын өөрчлөлтийг багасгах зэрэг Тогтвортой хөгжлийн тэргүүн зорилтуудад илүү анхаарал хандуулах шаардлагатайг Олон улсын Стандартын байгууллагаас тодорхойлон “Илүү сайхан дэлхийн төлөө хамтын зорилго” уриатайгаар Дэлхийн стандартын өдрийг тэмдэглэж байгааг Монгол Улсын Засгийн газар талархан дэмжиж байна.

Монгол Улсын Засгийн газраас Монгол Улсын урт, дунд хугацааны хөгжлийн бодлогод үндэслэн цар тахлыг богино хугацаанд эрсдэл багатай даван туулах, эдийн засгаа сэргээх, иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлэх, шударга ёс, цахим засаглалыг бэхжүүлэх зорилтыг дэвшүүлэн, шинэ сэргэлтийн бодлогоо тодорхойлон ажиллаж байгаа энэ үед стандартын салбарынхан тогтвортой хөгжлийг хангахад чиглэсэн уриалга дэвшүүлэн, чиг шугамаа болгон ажиллаж байгаад талархалтай байна.

Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, “Тогтвортой хөгжлийн зорилго”-ыг хэрэгжүүлэхэд стандартчилал, хэмжил зүйн байгууллагын үүрэг оролцоо нэн чухал. Стандартчилал, хэмжил зүйн салбарын албан хаагчид та бүхэн гаргасан амжилтаа ахиулан бататгаж, байгууллагын үйл ажиллагааны шинэчлэл, өөрчлөлтийг улам бүр идэвхижүүлэн, стандарт, хэмжил зүйн байгууллагын олон талт хамтын ажиллагааг өргөжүүлэн, сахилга, хариуцлага, манлайлал, хөдөлмөрийн бүтээмжийг салбарын бүх түвшинд дээшлүүлэн, эрчимжүүлж ажиллана гэдэгт эргэлзэхгүй байна.

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан бүтээн байгуулалт, мега төслийг дэмжих, технологид суурилсан инновацийг бий болгохын тулд олон улсын стандартыг нутагшуулах, олон улсын түвшинд нийцсэн үндэсний стандартыг бий болгох зорилтуудыг хэрэгжүүлж байна.

Стандартчилал, хэмжил зүйн салбарын ажилтан, албан хаагчид болон хэрэглэгчид Та бүхэнд “Стандартчилал, Хэмжил зүйн ажилтны өдөр” болон “Дэлхийн стандартын өдөр”-ийн мэндийг дахин дэвшүүлж, Монгол Улсын Засгийн газрын нэрийн өмнөөс болон хувиасаа халуун баяр хүргэж, ажил хөдөлмөрийн өндөр амжилтыг хүсэн ерөөе.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН,
ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮН,
МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД

САЙНБУЯНГИЙН АМАРСАЙХАН

СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗРЫН ДАРГЫН

МЭНДЧИЛГЭЭ

Монгол Улсад стандартчилал, хэмжил зүйн байгууллага үүсэн байгуулагдаад 98 жил болж байна.

Энэхүү салбарын түүхийг бичсэн Стандарт хэмжил зүйн салбарын үе үеийн эрхэм буурлууддаа стандартчилал, хэмжил зүй, сорьцын хяналтын үйл ажиллагааг олон улсын түвшинд хүргэхээр ажиллаж буй ниит ажилтан, албан хаагчиддаа "Стандартчилал, Хэмжил зүйн ажилтны өдөр" болон "Дэлхийн стандартын өдөр"-ийн мэндчилгээг дэвшүүлж, эрүүл энх, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

Стандарт, хэмжил зүйн салбарын хамт олон бид Монгол Улсын хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн улс орны нийгэм, эдийн засгийн хөгжлийг хурдасгах, үндэсний үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд стандартчилал, хэмжил зүй, сорьцын хяналт, тохирлын баталгаажуулалтын бодлогоор дэмжлэг үзүүлэх, олон улсын нийтлэг чиг хандлагатай уялдуулан хөгжүүлэхээр ажиллаж байгаа билээ.

Шинэчлэн батлагдсан Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль, Хэмжил зүйн тухай хуулиудыг хэрэгжүүлэх, Улсын Монгол Улсын Их Хурлаас баталсан "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр зэрэг бодлогын баримт бичигт тусгагдсан зорилго, зорилтуудыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Стандарт, хэмжил зүйн газар дунд хугацааны стратегийн төлөвлөгөөгөө боловсруулан ажиллаж байна.

Заримаас нь дурьвал бид 2024 он гэхэд төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах зорилтын хүрээнд үйл ажиллагааныхаа ил тод байдлыг хангах, төсөв санхүү, ажиллах орчин, боловсон хүчний чадавхи, гадаад хамтын ажиллагааны үйл ажилагаагаа сайжруулах, салбарын зарим үйлчилгээг цахимаар үзүүлэх, чанар хүртээмжийг нэмэгдүүлэх, хэмжлийн шинэ эталоныг бий болгох, хэмжлийн нэгж дамжуулалт, нарийвчлал, техникийн чадавхийг бэхжүүлэх, сорьцын хяналтын тогтолцоог боловсронгуй болгож хэрэглэгчийн эрхийг хамгаалах, бүтээгдэхүүн, тогтолцооны баталгаажуулалтыг олон улсын баримт бичиг, стандартад нийцүүлэн улам хөгжүүлэх, үндэсний стандартын үзүүлэлт, шаардлагыг олон улсын стандартын түвшинд хүргэх, нийцүүлэх гэх мэт олон зорилтыг дэвшүүлэн ажиллаж байна. Жил бүрийн 10 дугаар сарын 14-ны энэ өдрийг олон улсад "Дэлхийн стандартын өдөр" болгон тэмдэглэн өнгөрүүлдэг уламжлалтай.

Олон улсын стандартын байгууллага, Олон улсын цахилгаан техникийн комисс, Олон улсын харилцаа холбооны байгууллага энэ жил "Илүү сайхан дэлхийн төлөө хамтын зорилго" уриатайгаар тэмдэглэж буй Дэлхийн стандартын өдрөөр тогтвортой хөгжлийн суурь зорилтуудыг чухалчилж, түүнийг хэрэгжүүлэхэд стандарт ямар чухал болохыг онцлон харуулахыг зорьж байна.

Стандарт, хэмжил зүйн газар үндэсний стандартад олон улс, бүс нутаг, гадаад орны стандарттай ижилтгэсэн, нэвтрүүлсэн стандартын эзлэх хувийг нэмэгдүүлэх стратегийн зорилтыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Энэхүү зорилтыг нийгэмд үр дүнтэй, үр ашигтай хэрэгжүүлэхэд олон улсын гишүүнээр элссэн байгууллага, хоёр талт хамтын ажиллагаатай хөгжингүй орнуудын тэргүүн туршлага чухал үүрэг гүйцэтгэдэг.

Олон улсын байгууллагуудын гишүүний хувьд бид тэдний стратеги төлөвлөгөө, хэтийн зорилгыг хамтдаа хэрэгжүүлж, дэлхийн түвшинд хамтдаа алхаж, илүү сайхан дэлхийн төлөө нэгдмэл зорилготойгоор ажиллаж чадна. Дэлхийн сайн сайхны төлөөх бидний хамтын санаа, зорилго улам бүр дэлгэрэх болтугай.

СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗРЫН ДАРГА
Б.БИЛГҮҮН

ИНЬ БЯО ШУ

IEC Ерөнхийлөгч

ЭДДИ НЬОРОГЕ

ISO Ерөнхийлөгч

ХОУЛИНЬ ЧЖАО

ITU Ерөнхий нарийн бичгийн дарга

ИЛҮҮ САЙХАН ДЭЛХИЙН ТӨЛӨӨ ХАМТЫН ЗОРИЛГО

Нийгмийн тэнцвэргүй байдлыг арилгах, тогтвортой эдийн засгийг хөгжүүлэх, уур амьсгалын өөрчлөлтийн хурдыг сааруулах зорилготой Тогтвортой хөгжлийн зорилтууд (ТХЗ) нь дэлхий нийтэд маш өндөр ач холбогдолтой юм. Энэ зорилтуудад хүрэхийн тулд төр, олон нийтийн, хувийн түншүүд хоорондын хамтын ажиллагаа, олон улсын стандарт, тохирлын үнэлгээ зэрэг бүх боломжтой хэрэгслийг ашиглах шаардлагатай. Нийгмийг хүчирхэгжүүлж, илүү уян хатан, илүү эрх тэгш болгохын төлөө бид тогтвортой хөгжлийн зорилтуудад нэгдмэл байдлаар анхаарлаа хандуулах зайлшгүй шаардлага үүсээд байгааг дэлхий даяар үргэлжилсээр буй цар тахлын эсрэг хүчтэй тэмцэл нь харуулсан билээ. Өнөөдөр дахин сайжруулж бүтээн байгуулахад ТХЗ нь өндөр ач холбогдолтой болохыг батлаж өөрт ногдсон үүргээ биелүүлэх үйлсэд нэгдэхийг та бүхнээс хүсч байна. Энэхүү эрмэлзэлд стандартууд өмнө хэзээ ч байгаагүй ихээр хамааралтай болсон. Стандартын систем нь бүхэлдээ хамтын ажиллагаан дээр тулгуурладаг. Энэ нь бидний хамтын ажиллагааны хүч чадал нэгжүүдийн нийлбэрээс илүү хүчтэй гэдэгт итгэх хэрэгтэйг нотолж байна. Хамтран ажилласнаар тогтвортой байдлын сорилттой тулгарах үед бид түрүүлж алхан бодит амьдралын шийдлээр хүмүүсийг чадавхжуулж байна. Олон улсын стандартууд нь ТХЗ-ийг амжилттай хэрэгжүүлэхэд хэрхэн хувь нэмрээ оруулах олон арга замыг олон нийтэд түгээн дэлгэрүүлсэн олон жилийн Дэлхийн Стандартын Өдрийн аялалд бид яг ийм сэтгэлээр оролцдог. Бид 2030 оны хөтөлбөрийн хэрэгжилтийг хурдасгахын тулд Тогтвортой хөгжлийн зорилтуудад нийцсэн стандартууд, ИЛҮҮ САЙХАН ЕРТӨНЦИЙН ТӨЛӨӨ ЗОРИЛГОО нэгтгэн хамтран ажиллахад нэгдэж байна.

Орчуулсан СТУБГ-ын мэргэжилтэн Ш.Тэгшжаргал



ОЛОН УЛСЫН ЦАХИЛГААН ТЕХНИКИЙН ХОРООНЫ 85 ДУГААР ЕРӨНХИЙ ЧУУЛГАН БОЛЛОО

Олон Улсын Цахилгаан Техникийн Хорооны 85 дугаар Ерөнхий Чуулганы нээлт энэ сарын 03-ны өдөр боллоо. Тус чуулган нь Арабын Нэгдсэн Эмират Улсын Дубай хотноо энэ сарын 03-ны өдрөөс 08 хүртэл үргэлжилсэн бөгөөд биечлэн болон цахимаар зохион байгуулагдсан юм. Энэ жилийн Ерөнхий Чуулган "Аж үйлдвэрийн 4 дүгээр хувьсгалыг стандартчилалаар тэргүүлье" уриан дор зохион байгуулж байна. Тус чуулганд нийт 215 төлөөлөгч оролцож байгаа бөгөөд нээлтийн арга хэмжээнд 100 гаруй төлөөлөгч цахимаар оролцлоо.

Монгол Улсыг төлөөлөн Стандарт, хэмжил зүйн газрын Стандартчилал, тохирлын үнэлгээний бодлогын газрын дарга Б.Эрдэнэзул биечлэн оролцсон бөгөөд Стандарт, хэмжил зүйн газрын дарга Б.Билгүүн болон тус газрын мэргэжилтнүүд цахимаар оролцлоо.

Монгол Улсын Стандарт, хэмжил зүйн газар нь Олон Улсын Цахилгаан Техникийн Хорооны Түнш орны хөтөлбөрт 2000 онд нэгдсэнээс хойш стандартчиллын салбарт сайн туршлагыг нэвтрүүлж, хүний нөөцөө чадавхижуулан, үр ашгийг нь хүртэж ирсэн.

2021 оны эхнээс Монгол Улсын Стандарт, хэмжил зүйн газрын Стандартчилал, тохирлын үнэлгээний бодлогын газрын дарга асан Г.Батцэнгэл Монгол улсаа төлөөлөн Олон Улсын Цахилгаан техникийн хорооны Түншлэгч орны хөтөлбөрийг даргалж байгаа юм.

Дэлхий нийтийг хамарсан цар тахлын улмаас цахим хувьсал эрчимтэй явагдаж байна. Энэ жилийн Ерөнхий Чуулганаар дэвшилтэт технологийн хөгжилд өндөр ач холбогдол өгч, стандартчилал дахь технологийн дэвшил, хиймэл оюун ухаан, цахим инновацийг улс орны нийгэм, эдийн засаг, байгаль орчинд ээлтэйгээр хэрхэн ашиглаж болох талаар их судалж, алхам алхмаар ахисаар байна. Монгол Улс Олон Улсын Цахилгаан Техникийн Хорооны Түншлэгч орны хөтөлбөрт хамрагдаж, тус хөтөлбөрийг даргалж буйн хувьд дэлхийн өндөр хөгжилтэй орнуудтай зэрэгцэн урагшлах боломж бүрдээд байна.

Захиргаа удирдлагын газрын
Гадаад харилцааны мэргэжилтэн
Э.Билгүүнгэрэл

“ИРЭЭДҮЙ ХЭДИЙНЭ ЭХЭЛЧИХСЭН” УРИАН ДОР ISO WEEK ЗОХИОН БАЙГУУЛЛАА

Олон Улсын Стандартчиллын Байгууллагын Ерөнхий Ассамблейг 2021 оны 09 дүгээр сарын 22-24-ний хооронд Британийн Стандартын Хүрээлэн (BSI) өөрийн улсдаа зохион байгуулаа.

Энэхүү өндөр ач холбогдолтой, тэмдэглэлт арга хэмжээг тохиолдуулан Британийн Стандартын Хүрээлэн /BSI/ - гээс Олон улсын стандартчиллын байгууллагын долоо хоног (ISO Week)-т цахим арга хэмжээ, вэбинар, үзэсгэлэнгүүд болов.

Олон Улсын Стандартчиллын Байгууллагын Ерөнхий Ассамблейн арга хэмжээнүүдэд Монгол Улсын Стандарт, хэмжил зүйн газрын дарга Б.Билгүүн болон Стандартчилал, тохирлын үнэлгээний бодлогын газрын мэргэжилтнүүд цахимаар оролцсон юм. Ерөнхий Ассамблейн үеэр Ерөнхий Нарийн Бичгийн дарга Ноён Кэвин МкКинлэй өнгөрсөн онд хийж гүйцэтгэсэн ажлын тайланг танилцуулж, 2022-2024 онд ажиллах Зөвлөлийн гишүүдийг сонгох сонгуулийн дүн, 2022-2023 онд ажиллах Бодлогын Ерөнхий сайд, Техникийн удирдлагын Ерөнхий сайд, Санхүүгийн Ерөнхий сайдыг сонгох сонгуулийн дүнг танилцуулав. Манай Стандарт, хэмжил зүйн газар Олон улсын стандартчиллын байгууллагын бүрэн эрхтэй гишүүний хувьд дээрх сонгуулиудад оролцож саналаа өглөө.

ISO Week арга хэмжээг жил бүр тогтмол зохион байгуулдаг бөгөөд Ерөнхий Ассамблейн чуулганаар ISO-ийн 165 гишүүн байгууллага (үндэсний стандартын байгууллагууд)-ын мэргэжилтэн нар дэлхий нийтийг хамарсан асуудлуудыг хэлэлцэхээр цугларч, ISO-ийн үйл ажиллагааг тасралтгүй сайжруулж, бэхжүүлэх чухал шийдвэрүүдийг гаргадаг. Тус тэмдэглэлт долоо хоногт ISO-ийн Зөвлөл, Техникийн Удирдлагын Зөвлөл зэрэг ISO-ийн гол удирдах байгууллагууд мөн уулзалтуудаа зохион байгуулав.

Дэлхий нийтийг хамарсан Ковид-19 цар тахлын үр нөлөөгөөр бид ажиллах, аялах шинэ арга хэлбэрт дасан зохицож буй энэ үед энэ жилийн ISO Week-ийн “**Ирээдүй аль хэдийн эхэлчихсэн**” уриан дор болою.

ISO Week-ийн цахим платформ дээр Манай гарагийн ирээдүй, Нийгэм, Ажил зэрэг сэдэвчилсэн арга хэмжээнүүд явагдсан ба төлөөлөгчид өөрсдийн сонирхсон арга хэмжээнүүдийг сонгон оролцох боломжийг олгосон байна. Тус арга хэмжээний үеэр ISO-ийн болон гишүүн байгууллагуудын удирдлагууд, манлайлагчдын санаа бодлыг сонсож, дэлхий нийтэд тулгараад буй сорилтуудыг ISO Стратеги 2030-ийн тусламжтай хэрхэн давж болох талаар санал солилцов.

Гадаад харилцааны мэргэжилтэн
Э.Билгүүнгэрэл

КОВИДБАСТАНДАРТ

Стандарт, хэмжил зүйн газар нь КОВИД-19 дэгдэж эхэлсэн үеэс Засгийн газраас хэрэгжүүлж буй цар тахлын эсрэг шуурхай арга хэмжээг дэмжин ажилласан. Үүнд, цар тахлын бэлэн байдал, хариу арга хэмжээ авах чадавхийг сайжруулах, яаралтай тусламжийн нэн шаардлагатай тоног төхөөрөмж, хамгаалалтын хувцас хэрэгсэл, аюулгүй байдлын эрсдэлийг удирдах, ариутгал халдваргүйтгэлийн чиглэлээр стандартын санд байгаа үндэсний стандартыг олон нийтэд мэдээлэх, олон улс, бүс нутгийн стандартыг орчуулан үндэсний болгоход дэмжлэг үзүүлэх, үндэсний стандарт боловсруулах, батлах ажлыг зохион байгуулан ажиллаж байна.

Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээтэй холбоотой байж болох Монгол Улсын үндэсний стандартын санд байгаа Эмнэлгийн зориулалттай нэг удаагийн хамгаалах хэрэгслийн стандарт:

1. Эрүүл мэндийн зориулалттай нэг удаагийн хэрэгсэл. 1-р хэсэг. Малгай. Техникийн шаардлага MNS 6623-1:2016
2. Эрүүл мэндийн зориулалттай нэг удаагийн хэрэгсэл. 2-р хэсэг. Амны хаалт. Техникийн шаардлага MNS 6623-2:2016
3. Эрүүл мэндийн зориулалттай нэг удаагийн хэрэгсэл. 3-р хэсэг. Халаад. Техникийн шаардлага MNS 6623-3:2016
4. Эрүүл мэндийн зориулалттай нэг удаагийн хэрэгсэл. 4-р хэсэг. Гутлын өмсгөл. Техникийн шаардлага MNS 6623-4:2016
5. Эрүүл мэндийн зориулалттай нэг удаагийн халдвар хамгаалллын хэрэгсэл. Комбинзон болон гутлын гадуур өмсгөлийн иж бүрдэл. Техникийн шаардлага MNS 6853:2020

Ариутгал, халдваргүйтгэлтэй холбоотой болон гадаргуун идэвхт бодисын стандарт:

1. Халдваргүйжүүлэлтийн явуулын байранд тавих техникийн ерөнхий шаардлага MNS 6407:2013
2. Халдваргүйжүүлэлтийн суурин байранд тавих техникийн ерөнхий шаардлага MNS 6408:2013
3. Зоонозын халдварт өвчний оношлогоо, шинжилгээ судалгаанд хэрэглэх биобэлдмэл, тэжээлт орчин, багаж хэрэгслийг ариутгах техникийн шаардлага MNS 5765:2021
4. Зоонозын халдварт өвчний халдвартай ба сэжигтэй материалыг халдваргүйжүүлэх техникийн шаардлага MNS 5766:2021
5. Эмнэлгийн зориулалттай нэг удаагийн хог хаягдлын хайрцаг. Техникийн ерөнхий шаардлага MNS 5525:2005
6. Септидин 1%, 10%-ийн уусмал.Ерөнхий шаардлага MNS 6150:2010
7. Бензалкониум хлоридын 0,1%; 1,0%; 4,0 %-ийн уусмал. Ерөнхий шаардлага MNS 6158:2010
8. Этилийн спиртийн гар халдваргүйжүүлэгч гель. Ерөнхий шаардлага MNS 6159:2010
9. Повидон иодын (ПВП-иод) 7,5 хувийн шингэн саван. Ерөнхий шаардлага MNS 6161:2010
10. Повидон иодын (ПВП-иод) 0,7%-ийн ам зайлах уусмал. Ерөнхий шаардлага MNS 6162:2010
11. Поливинилийн спирт – иодын 0,5%; 1,0%-ийн уусмал. Ерөнхий шаардлага MNS 6163:2010
12. ЭМ технологийн цуврал био бүтээгдэхүүн. Халдваргүйтгэлийн био бэлдмэл “Тамир-Эм”. Техникийн шаардлага MNS 6445:2014
13. Гар нүүрийн саван Техникийн ерөнхий шаардлага MNS 0241:1998

COVID-19-ийн цар тахлын үед эмнэлгийн хамгаалах хэрэгсэл үйлдвэрлэх, ханган нийлүүлэх, тэдгээрийн чанарт тавих хяналтыг сайжруулахад тавих шаардлагыг дэмжих зорилгоор Олон улсын болон гадаад орны дараах стандартыг орчуулан батлуулав. Үүнд:

MNS ISO 13485:2021 Эмнэлгийн хэрэгсэл. Чанарын удирдлагын тогтолцоо. Зохицуулалтын зорилгоор тавих шаардлага

Энэхүү стандартаар эмнэлгийн багаж хэрэгслийн ашиглалтын мөчлөгийн нэг буюу хэд хэдэн үе шатанд хамрагдах байгууллагын чанарын удирдлагын тогтолцоонд тавих шаардлагыг тодорхойлно. Стандартыг эрүүл мэндийн байгууллагуудад эм, эмнэлгийн хэрэгслийн түүхий эд, эд анги, дэд бүтэц, эмнэлгийн хэрэгсэл, ариутгалын үйлчилгээ, тохируулгын үйлчилгээ, түгээлтийн үйлчилгээ, засвар үйлчилгээ үзүүлэгч эсхүл ханган нийлүүлэгч талууд ашиглах боломжтой.

Эмнэлгийн хэрэгслийн нийлүүлэлтийн сүлжээнд харилцан адилгүй үүрэг гүйцэтгэдэг байгууллагууд нь чанарын удирдлагын тогтолцоог хэрэгжүүлэхэд хэд хэдэн чиглэлээр зохицуулалтын шаардлага тавьдаг. Энэхүү ОУ-ын стандарт нь байгаль орчны менежмент, хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй байдлын менежмент, санхүүгийн менежмент зэрэг бусад менежментийн системд хамаарах шаардлагыг оруулаагүй болно.

Гэсэн хэдий ч энэхүү олон улсын стандарт нь байгууллагад өөрийн чанарын удирдлагын тогтолцоог холбогдох удирдлагын системийн шаардлагуудтай уялдуулах, нэгтгэх боломжийг олгодог. Байгууллага нь энэхүү олон улсын стандартын шаардлагад нийцсэн чанарын удирдлагын тогтолцоог бий болгохын тулд одоо байгаа менежментийн системтэй зохицуулах буюу уялдуулах боломжтой юм.

MNS ISO 10993-1:2021 Эмнэлгийн хэрэгслийн биологийн үнэлгээ. 1-р хэсэг: Эрсдэлийн менежментийн үйл явцын үнэлгээ ба туршилт

Энэхүү стандартын зорилго нь хүн төрөлхтнийг эмнэлгийн хэрэгслийн хэрэглээнээс үүсч болзошгүй биологийн эрсдэлүүдээс хамгаалах юм. Энэхүү баримт бичгийг эмнэлгийн хэрэгслийн биологийн үнэлгээний талаарх хэд хэдэн Олон улсын болон үндэсний стандартууд болон журмуудаас эмхэтгэн гаргасан аргачлал нь ашиглагдаж буй бүх өгөгдлийг хянах, үнэлэх ажлыг, шаардлагатай бол нэмэлт туршилтыг сонгож хэрэглэхийн зэрэгцээ, эмнэлгийн хэрэгсэл тус бүрт биологийн хариу урвалыг ашиглах аюулгүй байдалтай холбоотой цогц үнэлгээ хийх боломжийг олгодог.

MNS EN 13795-1:2021 Мэс заслын хувцас ба хэрэглэл. Тавих шаардлага ба туршилтын арга. 1-р хэсэг: Мэс заслын нөмрөг ба халад

Энэхүү стандарт нь материал болон бүтээгдэхүүний шинж чанар, гүйцэтгэлийн шаардлагын талаар үйлдвэрлэгчид болон гуравдагч этгээдийн хоорондын харилцаанд туслах зорилготой. Стандартаар нэг удаагийн болон дахин ашиглах боломжтой мэс заслын хувцас, нөмрөгний аюулгүй байдлыг ижил түвшинд хангах, бүтээгдэхүүн зохион бүтээх, боловсруулах, үнэлэх, сонгоход үйлдвэрлэгчид болон хэрэглэгчдэд туслах зорилготой.

MNS ASTM E 1174:2021 Эрүүл мэндийн ажилтны гар угаах ажлын үр дүнг үнэлэх туршилтын арга

Энэ стандартаар нянгийн эсрэг гар угаах бодисыг эрүүл мэндийн ажилтны гар угаах үйлдэлд ашигласан үр дүнг нян судлалын дээж авч туршилт хийх, шинжилгээний дүнг харьцуулах, ашиглах шаардлагыг тогтооно.

MNS ASTM F 1494:2021 Хамгаалалтын хувцасны нэр томъёо

Энэхүү стандартаар хүний биеийг бичил биетний халдварлалт, химийн болон биологийн гаралтай бодисын нөлөөллөөс хамгаалж чадахуйц шаардлага хангасан малгай, халад, комбинзон, нүдний шил,

амны хаалт, малгай, гутал, бээлий болон тэдгээрийн бүрдэл хэсэгтэй хамааралтай нэр томьёог нэгтгэн тогтоосон. Мөн хамгаалалтын хувцас үйлдвэрлэх, ариутгах, цэвэрлэхтэй холбоотой зарим нэр томьёо орсон.

MNS ASTM F 3387:2021 Амьсгалын замыг хамгаалах хэрэгсэл

Стандартаар мэргэжлээс шалтгаалах амьсгал хамгаалах хэрэгслийг ашиглах зөвшөөрөгдсөн дадлыг тогтоох, амьсгал хамгаалах хэрэгслийг зөв сонгох, ашиглах, засвар үйлчилгээ хийх талаар мэдээлэл, удирдамжаар хангах шаардлагыг тогтооно. Мөн амьсгал хамгаалах хөтөлбөрийг бий болгох, хэрэгжүүлэх, үнэлэхэд тавих шаардлагыг агуулсан болно.

MNS ASTM D 6319:2021 Эмчилгээ, үзлэгийн зориулалтын нитрил бээлий хийх үзүүлэлт

Стандартаар эрүүл мэндийн үзлэг, оношилгоо, эмчилгээний үйлдэл хийхэд хэрэглэх резинэн бээлийнд тавих ерөнхий шаардлагыг тогтоосон. Чанарын шаардлагад нүх сүв, насжилт, ариун чанарт тавих шаардлага, физикийн үзүүлэлт хэмжээнүүд, зузаан, суналт зэрэгт тавих шаардлагыг тодорхойлсон.

Аюулгүй байдал, уян хатан байдал Онцгой байдлын удирдлага Осол аваарын үеийн менежмент удирдамж MNS ISO 22320:2020

Сүүлийн жилүүдэд байгалийн болон хүний оролцоотой тохиолдсон байгалийн гамшиг, мөн бусад томоохон осол аваар нь хүний амь насыг хамгаалах, хохирол, эвдрэлийг бууруулах, нийгмийн амин чухал үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангахад осол аваарын үеийн менежмент чухал ач холбогдолтой болохыг харуулсан.

Ийм чиг үүрэгт эрүүл мэнд, харилцаа холбоо, ус, хүнсний хангамж, цахилгаан, түлшний хүртээмж орно. Өмнө нь осол аваарын үеийн менежмент нь үндэсний, бүс нутгийн эсвэл тусдаа байгууллагуудын хүрээнд төвлөрдөг байсан бол өнөөдөр болон ирээдүйд үндэстэн дамнасан, зохион байгуулалттай арга барил шаардлагатай байна. Энэхүү хэрэгцээ нь олон улсын түвшинд засгийн газар, төрийн бус байгууллага (ТББ), иргэний нийгмийн байгууллагууд (ИНБ), хувийн хэвшлийн хоорондын уялдаа, харилцан хамаарлаас үүдэлтэй юм.

Хотжилт ихэссэн, чухал дэд бүтцийн уялдаа ба харилцан хамаарал, нийгэм, эдийн засгийн динамик, хүрээлэн буй орчны өөрчлөлт, амьтан ба хүний өвчлөл, дэлхийн хүн ам, бараа бүтээгдэхүүний хөдөлгөөн нэмэгдсэн зэрэг хүчин зүйлүүд нь газарзүйн болон улс төрийн хил хязгаараас давж, үйл ажиллагааны тасалдал, гамшгийн магадлалыг нэмэгдүүлэв.

Энэхүү баримт бичиг нь байгууллагад бүх төрлийн осол аваарыг (жишээлбэл, онцгой байдал, хямрал, тасалдал, гамшиг гэх мэт) зохицуулах ажлыг сайжруулах арга зүйн удирдамж болно. Осол аваарын үеийн менежментийн хэд хэдэн үйл ажиллагааг хувийн хэвшил, бүс нутгийн байгууллага, засгийн газрын өөр өөр харьяаллын түвшний байгууллагууд хамтран хэрэгжүүлдэг. Тиймээс осол аваарын үеийн менежментийг хэрхэн төлөвлөж, хэрэгжүүлэх талаар оролцогч бүх талыг чиглүүлэх шаардлага байна.

Осол аваарын менежментийн үед бүс нутаг хоорондын эсвэл бүс нутгийн тусламж нь осол аваарт өртсөн хүн амын хэрэгцээ, соёлын мэдрэмжтэй нийцэхүйц байх төлөвтэй байна.

Тиймээс шаардлагатай тохиолдолд осол аваарын үеийн менежментийг бий болгох, хэрэгжүүлэхэд олон нийтийн оролцоог нэмэгдүүлэхэд чиглэсэн олон талт оролцоог хангах нь зүйтэй юм. Оролцож буй байгууллагууд газарзүйн, улс төрийн болон зохион байгуулалтын хүрээнд нийтлэг хандлагыг хуваалцах чадварыг шаарддаг.

Энэхүү баримт бичиг нь орон нутгийн, бүс нутгийн, үндэсний, магадгүй олон улсын түвшинд гарсан осол

аваарт бэлтгэх, хариу өгөх дарааx үүрэг бүхий аливаа байгууллагад хамаарна. Үүнд:

a) осол аваарын бэлтгэлд оролцох, хэрэгжүүлэх хариуцлага хүлээсэн;

b) осол аваарын үеийн менежментийн заавар, чиглэл өгдөг;

c) олон нийттэй харилцаж, хамтран ажилладаг;

d) осол аваарын менежментийн чиглэлээр судалгаа хийдэг.

Осол аваарын үеийн менежментийн нийтлэг хандлага нь хамтын ажиллагааг идэвхжүүлж, байгууллагуудын хооронд илүү уялдаатай, нэмэлт арга хэмжээ авах боломжийг олгодог тул үр дүнтэй байдаг.

Ихэнх осол аваар орон нутгийн шинж чанартай байдаг бөгөөд орон нутгийн, хотын, бүс нутгийн, мужийн эсвэл улсын түвшинд удирддаг.

Аюулгүй байдал, уян хатан байдал Олон нийтийн тогтвортой байдал Онцгой байдлын үед эмзэг бүлгийн хүмүүсийг дэмжих удирдамж MNS ISO 22395:2020

Энэхүү стандарт нь онцгой байдлын үед хамгийн ихээр өртөх хүмүүсийг олж илрүүлэх, гамшиг, осол, онцгой байдалд бэлтгэх, хариу арга хэмжээ авах, сэргээн босгох үйл ажиллагаанд хэрхэн хамруулах талаарх заавар болно. Онцгой байдлын бэлэн байдал, хариу арга хэмжээ, сэргээн босгох бүхий л үе шатанд эмзэг бүлгийн хүмүүсийг таних, тэдгээрийг хамруулах шилдэг туршлагыг ойлгож, хэрэгжүүлэх нь чухал байдаг. Онцгой байдлын өмнө, тухайн үед болон дараа нь тусламж үзүүлэх тухай шийдвэр гаргахад эмзэг бүлгийн хүмүүсийг хамруулах бэлтгэл арга хэмжээ, эмзэг бүлгийн хүмүүс ба тэдгээрийн төлөөлөгчдийг хамруулах, чадавхийг бэхжүүлэх, олон нийтийн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн шаардлагатай төлөвлөлт, ойлголтыг нэмэгдүүлэхэд туслах, онцгой байдлын үед хувь хүний сайн сайхны төлөө хувь нэмрээ оруулахад эмзэг бүлгийн оролцоог хангах арга замыг тодорхойлсон.

Аюулгүй байдал ба уян хатан байдал Бизнесийн тасралтгүй байдлын менежментийн тогтолцоо Шаардлага MNS ISO 22301:2020

Энэхүү стандартад тухайн байгууллагын үйл ажиллагааны тасалдлыг хүлээж авах эс хүлээж авах нөлөөллийн төрөл ба хэмжээнд тохирсон бизнесийн тасралтгүй байдлын менежментийн тогтолцоог (БТМТ) нэвтрүүлэх ба хэрэгжүүлэх бүтэц болон шаардлагыг тусгасан. Үүнд:

- бизнесийн тасралтгүй байдлын бодлого, зорилтыг тодорхойлох байгууллагын хэрэгцээ ба шаардлагын тухай ойлголт;
- үйл ажиллагааны тасалдлыг даван туулахад шаардагдах байгууллагын үйл явцыг хэрэгжүүлэх хариу арга хэмжээний бүтэц болон чадавхи;
- БТМТ-ны гүйцэтгэл болон үр дүнгийн хяналт, мониторинг;
- чанарын болон тоон хэмжүүр дээр тулгуурласан байнгын сайжруулалт.
- Бизнесийн тасралтгүй байдлын менежментийн тогтолцооны зорилго нь үйл ажиллагаа зогссон тохиолдолд байгууллагын цаашдын үйл ажиллагааг удирдах чадварыг хянах, хангах, хадгалахад бэлтгэх явдал юм.

Тогтолцоог үр нөлөөтэй хэрэгжүүлэх, хадгалах, тасралтгүй сайжруулах зорилгоор Төлөвлө (бий болгох), Хий (хэрэгжүүлэх ба хадгалах), Шалга (хянах, үнэлэх), Гүйцэтгэ (хадгалах ба сайжруулах) мөчлөгийг ашигладаг.

Энэхүү стандартад бусад менежментийн тогтолцоонд тавих онцлог шаардлагыг агуулаагүй ч зарим нэг элементийг бусад менежментийн тогтолцоотой уялдуулан хэрэглэж болно.

Эрсдэлийн менежмент Удирдамж MNS ISO 31000:2021

Стандартыг эрсдэлийг удирдах, шийдвэр гаргах, зорилгоо тодорхойлох, түүнд хүрэх, гүйцэтгэлийг сайжруулах замаар байгууллагын үнэ цэнийг бий болгож, хамгаалдаг ажилтнууд ашиглана.

Эрсдэлийг удирдах нь засаглал болон манлайллын нэг хэсэг бөгөөд байгууллагыг бүх түвшинд удирдан чиглүүлэх үндэс суурь болдог. Энэ нь менежментийн тогтолцоог сайжруулахад хувь нэмэр оруулна.

Эрсдэлийн менежментийг энэхүү стандартад заасан зарчим, хүрээ, үйл явцад үндэслэн хэрэгжүүлдэг гэдгийг доорх зурагт тоймлон үзүүлэв. Эрсдэлийг үр ашигтай, үр дүнтэй, тууштай удирдахын тулд эдгээр бүрдэлийг өөрчлөх, сайжруулах шаардлагатайг стандартад тусгасан болно.

Эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, чанарын менежментийн тогтолцооны стандартчиллын ТХ-ны НБД Ц.Бурмаа



MNSISO/PAS45005:2021 СТАНДАРТ

“ХӨДӨЛМӨРИЙН ЭРҮҮЛ МЭНД, АЮУЛГҮЙ БАЙДЛЫН МЕНЕЖМЕНТ. COVID-19 ЦАРТАХЛЫН ҮЕДА АЮУЛГҮЙ АЖИЛЛАХ ЕРӨНХИЙ ЗААВАРЧИЛГАА”

“ISO/PAS45005:2020 OCCUPATIONAL HEALTH AND SAFETY MANAGEMENT-GENERAL GUIDELINES FOR SAFE WORKING DURING THE COVID-19 PANDEMIC”

Энэхүү баримт бичиг нь COVID-19 цар тахлын болон энэ өвчний бүх нөхцөлд байгаа хүмүүс, түүний дотор гэрээс эсвэл хөдөлгөөнт байрлалд ажилладаг хүмүүс, ажлын байранд байгаа ажилтан болон бусад оролцогч талуудын эрүүл мэнд, аюулгүй байдал, сайн сайхан байдалд үзүүлж буй эрсдэлд хариу арга хэмжээ авах зааварчилгаа юм.

Дэлхийн улс орнуудын Засгийн газар, эрх бүхий байгууллага болон бусад мэргэжлийн байгууллагаас COVID-19 цар тахлын үеийн аюулгүй ажиллагааны зааврыг боловсруулж гаргасан байна. Энэхүү баримт бичигт эдгээр мэдээлэл дээр нэмэлт болгож, дараах зарчимд үндэслэсэн ерөнхий зааварчилгааг өгнө. Үүнд:

- ажилтны болон холбогдох сонирхогч талуудын эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалахад чиглэсэн COVID-19 цар тахлаас үүдэлтэй эрсдэлийг удирдах үндэслэлтэй арга хэмжээ авч байгаа эсвэл цаашид авч хэрэгжүүлэх;
- эдгээр арга хэмжээг хэрэгжүүлээгүй тохиолдолд ажилтныг ажил хийхийг шаардахгүй байх.

Энэхүү зааварчилгаанд эдгээр эрсдэлийг хэрхэн удирдах талаар байгууллага, ажилтанд зориулсан практик зөвлөмжийг багтаасан ба үйл ажиллагаагаа сэргээж байгаа, цар тахлын үеэр үйл ажиллагаа нь хэвийн явагдаж байгаа, үйл ажиллагаагаа шинээр эхэлж байгаа аль ч байгууллагад хэрэглэхэд тохиромжтой.

Энэхүү зааварчилгаа нь ерөнхий бөгөөд бизнесийн болон үзүүлж буй үйлчилгээний шинж чанар, хэмжээ, нарийн төвөгтэй байдлаас үл хамааран бүх байгууллагад хэрэглэх боломжтой. Ихэнх жижиг хэмжээний байгууллагад эрүүл мэнд, аюулгүй байдал (ХЭМАБ), байгууламжийн менежмент, хүний нөөц зэрэг чиг үүргийн тусгай хэлтэс байдаггүй. Тодорхой чиг үүргийн талаар илүү дэлгэрэнгүй мэдээллийг мэргэжлийн байгууллага, үндэсний болон олон улсын стандартаас авах боломжтой.

Байгууллага энэхүү баримт бичигт заасан зааварчилгааг хэрэгжүүлэх нь дараах ач холбогдолтой. Үүнд:

a. ажилтан болон холбогдох бусад оролцогч талуудыг COVID-19-тэй холбоотой эрсдэлээс хамгаалах үр дүнтэй арга хэмжээ авна;
b. COVID-19-тэй холбоотой эрсдэлд чиглэсэн системтэй арга хэмжээ авч буйгаа харуулна;
c. өөрчлөгдөж буй нөхцөл байдалд үр дүнтэй, цаг тухайд нь дасан зохицох үндэс суурийг бий болгоно.

ISO 45001 стандартыг хэрэгжүүлсэн байгууллага энэ баримт бичгийг ашиглан ХЭМАБ-ын менежментийн тогтолцооны холбогдох заалтуудыг доор заасан Төлөвлөх-Хийх-Шалгах-Үнэлэх (PDCA) мөчлөгтэй холбож болно.

Системтэй арга хэмжээ нь COVID-19-тэй тэмцэхэд шаардлагатай нөөц, хүчийг зохион байгуулахад чухал ач холбогдолтой.

- Төлөвлөх: Аюулгүй ажиллахын тулд байгууллага юу хийх хэрэгтэй байгааг төлөвлөнө
- Хийх: Байгууллага төлөвлөсөн ажлаа хэрэгжүүлнэ.
- Шалгах: Ажил хир зэрэг сайн явагдаж буйг харна
- Үнэлэх: Асуудлыг арилгах ба байгууллага илүү үр дүнтэй ажиллах арга замыг тодорхойлно

Энэ баримт бичиг нь алхам алхмаар хэрэгжүүлэх багц зөвлөмж биш бөгөөд энэ нь байгууллага байнгын сайжруулалтыг хэрэгжүүлэх, цар тахлын янз бүрийн үе шатанд гарч буй өөрчлөлтөд хариу үйлдэл үзүүлэх боломжтой байхаар дээр дурдсан үргэлж идэвхтэй байх шаардлагатай PDCA мөчлөгийн бүх хэсгийг дахин давтан хэрэгжүүлэх хүрээг зааж өгнө.

Нийт ширхэгтийн үйлдвэрлэл – 111 сая тонн 2018 онд
Сүүлийн 10 жилд 35 сая тонн нэмэгдсэн
Байгалийн гаралтай ширхэгтийн хэмжээ- 32 сая тонн

Дэлхий даяар жилд – 80 тэрбум ширхэг хувцас үйлдвэрлэдэг
2000-2014 онд хувцас үйлдвэрлэл 2 дахин нэмэгдсэн
Дэлхий даяар 1 хүн жилд 5 кг хувцас худалдаж авдаг бол
ЕХ улс, АНУ-д 1 хүн жилд 16 кг хувцас худалдаж авч байна

УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТӨНД ТЕКСТИЛИЙН САЛБАРЫН ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨ





2015 оны байдлаар текстилийн үйлдвэрлэл 1.2 тэрбум тонн CO2 ялгаруулсан
Дэлхий даяарх агаарын ба усан замын тээврээс ялгаруулж байгаа CO2 –оос 21 дахин их

Жилд 0.5 сая тонн нийлэг ширхэгт далай руу хаягдаж байгаа

Жилд 2000 тн хортой химийн будаг ЕХ орнуудын хөрсөнд нэвчдэг

Нийт хувцасны дөнгөж 1% л дахин боловсруулалтанд ордог

Дэлхийн банкны судалгаагаар үйлдвэрийн хаягдал усны 20% текстилийн салбараас гардаг

Хэрэглэгчийн зан төлвийн өөрчлөлт

- Оролцогсдын 2/3 нь байгаль орчны сөрөг нөлөөллийг хязгаарлах
- 88% нь бохирдлыг бууруулах
- 57% нь байгаль орчны сөрөг нөлөөг бууруулахын тулд амьдралын хэв маягаа өөрчлөх
- 60% нь дахин боловсруулах боломжтой болон эко савлагаатай бүтээгдэхүүн сонгох
- 55% нь ААН-үүд ажиллагсдынхаа эрүүл мэндэд анхаарах
- 38% нь Азийн үйлдвэрүүдийн хэт хямд цалин хөлстэй ажиллагсдад туслах шаардлагатай гэжээ



MNS 6926 : 2021 Текстилийн тогтвортой үйлдвэрлэлийн – Удирдамж

Текстилийн стандартчиллын Техникийн хороо (ТХ 16)-ны хурлаар хэлэлцүүлж, СХЗГ-ын даргын 2021 оны 07 дугаар сарын 22-ны өдрийн С/39 дугаар тушаалаар батлагдсан MNS 6926 : 2021 Текстилийн тогтвортой үйлдвэрлэлийн - Удирдамж стандартыг батлагдсан.

Стандартынзорилго

- Монголын текстилийн салбарын тогтвортой байдлыг хангах
- Байгальд ээлтэй аргаар боловсруулсан бүтээгдэхүүнийг зах зээлд таниулах
- Тогтвортой ноос ноолууран бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх
- Ноос ноолуурын салбарт ногоон санхүүжилт нэмэгдэнэ
- Үйлдвэрүүдийн ашиглалтын зардал хэмнэгдэнэ

Ачхолбогдол

- Ноос ноолуурын үйлдвэрүүдийн байгаль орчин, нийгмийн нөлөөлөл сайжирна
- Тогтвортой бүтээгдэхүүний эрэлт хэрэгцээ ихсэж буй Европ болон дэлхийн бусад зах зээлд нэвтрэх боломж өснө

ОлонУлсынстандартуудтайуялдуулж,харьцуулсанбайдал

Стандартууд	Байгаль орчны шалгуур	Нийгмийн хариуцлагын шалгуур	МАА холбоотой шалгуур
MNS6 926:2021 Текстилийн тогтвортой үйлдвэрлэл-Удирдамж	15 шалгуур	28 шалгуур	2 шалгуур
STeP by Oeko Tex	37 ижил шалгуур		IFOAM бүлэг стандартаар зохицуулдаг
GOTS	28 ижил шалгуур		Байхгүй
ISO1 4000	17 ижил шалгуур		Байхгүй
NordicE colabel	14 ижил шалгуур		Байхгүй

СТҮБГ-ын мэргэжилтэн Ч.Пүрэвдулам

MNS 6891:2020 “Хариуцлагатай нүүдэлчин зохистой дадлыг нэвтрүүлэхэд тавих шаардлага” стандартыг боловсруулахад дор дурдсан бодлогын баримт бичгүүдийн зорилтуудыг үндэслэн ХХААХҮЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар баталсан ажлын хэсэг боловсруулж, СХЗГ-ын дэргэдэх ХАА-н стандартчиллын Техникийн хороо (ТХ 17)-ны хурлаар хэлэлцүүлж, СХЗГ-ын даргын 2020 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн С/55 дугаар тушаалаар баталсан.

- АЛСЫН ХАРАА 2050,
- МОНГОЛ МАЛ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР,
- ҮНДЭСНИЙ ЧАНАРЫН ХӨТӨЛБӨР,
- ҮЙЛДВЭРЖИЛТ 21:100 ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР,
- НООЛУУР ХӨТӨЛБӨР зэрэг хөтөлбөрийг хэрэгжүүлэх,
- Монгол малын гаралтай бүтээгдэхүүний дэлхийн зах зээлд өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх
- Бэлчээрийн мал аж ахуйн анхан шатны үйлдвэрлэгчийн түвшинд малын тавлаг байдлыг хангах, хариуцлагатай нүүдэлчин тогтолцоог хэрэгжүүлэхэд баримтлах үндсэн зарчим, шаардлагыг тогтоох;
- Дэлхийн зах зээлийн хэрэглэгчдийн шаардлагад нийцүүлэн гарал үүсэл тодорхой, байгаль, мал амьтанд ээлтэй, чанартай, хариуцлагатай мал аж ахуйгаас бэлтгэсэн түүхий эдийг баталгаажуулахад хэрэглэх стандарттай болох; Нүүдлийн мал аж ахуйн үйлдвэрлэлийг тогтвортой эрхлэх зорилгоор:

Монгол орны бэлчээрийн мал аж ахуйг хөгжүүлэхэд мал, амьтны эрүүл мэндийг хамгаалж, тавлаг байдлыг хангах, байгаль орчин, бэлчээр, тэжээл, усны хангамжийг зөв зохистой ашиглах, малын үржүүлэг селекц, тэжээллэг, арчилгаа, маллагаа зэрэг мал аж ахуйн үйлдвэрлэлийг тогтвортой эрхлэхэд тавих анхан шатны зохистой дадлыг нэвтрүүлэхэд тавих шаардлагыг тогтоож өгсөн. Бэлчээрийн мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгч этгээд, сум, баг, малчдын бүлэг, хоршоо, сургалт болон тохирлын үнэлгээний байгууллагууд хэрэглэнэ.

Дэлхий нийтийн чиг хандлага

Гарал үүсэл тодорхой, баталгаатай, ээлтэй бүтээгдэхүүн

- Бэлчээрийн эрүүл байдал
- Малын эрүүл байдал
- Малын тавлаг байдал
- Малын эрх чөлөөг хангасан байдал
- Бүтээгдэхүүний чанар

Монголын мал аж ахуйн давуу тал

• Нүүдлийн соёлтой • Байгалиа хайрладаг • Мал сүрэг нь тааваараа

МАА-н тогтвортой хөгжлийн гарц болсон бэлчээрийн маллагаатай нүүдлийн соёл иргэншлээ хадгалсан мал аж ахуй, түүнээс гарах түүхий эдийг бүрэн боловсруулж, дэлхийн зах зээлд хэрэглэгчийн эрэлт шаардлагад тулгуурлан "Хариуцлагатай нүүдэлчин зохистой дадлыг нэвтрүүлэхэд тавих шаардлага" үндэсний стандартыг олон талын оролцоотойгоор боловсруулж батлуулахад Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Хөдөө аж ахуйн их сургууль, Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэн, Бэлчээр ашиглагчдын нэгдсэн холбоо болон Швейцарын хөгжлийн агентлагийн "Ногоон-Алт, Малын эрүүл мэнд" төслийн зүгээс дэмжлэг үзүүлэн ажилласан юм.

Дээрхстандартыгсурталчлантаниулах,хэрэгжөөж,нэвтрөөлэхзорилгоор:

2021 оны 9 дүгээр сарын 13-аас 17-ны өдрүүдэд Архангай аймгийн Цэцэрлэг хот, Чулуут, Их тамир сумдын төрийн албан хаагчид, малчдын хоршоодын дунд "Тогтвортой байдлын гэрчилгээжүүлэлт - Монголын ноос, ноолуурын үнэ цэнийг нэмэгдүүлэх арга зам" сэдэвт сургалтыг Европын холбооны Текстилийн тогтвортой үйлдвэрлэл ба эко тэмдэг төсөл**,** EU SWITCH-Asia Programme, Швейцарын хөгжлийн агентлагийн "Ногоон-Алт, Малын эрүүл мэнд" төсөл, Монголын бэлчээр ашиглагчдын нэгдсэн холбоод хамтарч зохион байгууллаа.

СХЗГ, Итгэмжлэлийн үндэсний төв, "Говь" ХК зэрэг байгууллага дэмжигч байгууллагаар оролцож стандарт, тохирлын үнэлгээ, баталгаажуулалт, итгэмжлэлийн талаарх улсын бодлого, эрх зүйн орчны талаар мэдээлэл өгч, MNS 6891:2020 Хариуцлагатай нүүдэлчин зохистой дадлыг нэвтрүүлэхэд тавих шаардлага, MNS 6926:2021 Текстилийн тогтвортой үйлдвэрлэл – Удирдамж стандартын уялдаа холбоо, ач холбогдлыг танилцуулсан.

СТҮБГ-ын мэргэжилтэн Ч.Пүрэвдулам

ЖУУЛЧНЫ МЭДЭЭЛЛИЙН ТӨВИЙГ ОЛОН УЛСЫН ТҮВШИНД ХҮРГЭХ БОЛОМЖ БҮРДЛЭЭ

Монгол Улсын аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг сурталчлах, гадаад, дотоодын аялагчдыг шаардлагатай аяллын мэдээ, мэдээллээр хангах, зөвлөгөө өгөх зорилго бүхий "Жуулчны мэдээллийн төв"-үүдийг бий болгох, ялангуяа олон улсын түвшинд хүрэхүйц үйлчилгээ үзүүлэх боломжийг бүрдүүлэх үүднээс **"Жуулчны мэдээллийн төв - Жуулчинд мэдээлэл өгөх ба жуулчдыг хүлээн авах үйлчилгээ-Шалгуур үзүүлэлт MNS ISO 14785: 2021"** стандартыг Аялал жуулчлалын хөгжлийн төвөөс боловсруулж, Стандарт, хэмжил зүйн газрын дэргэдэх Аялал жуулчлалын стандартчиллын техникийн хороо /ТХ-40/-ны хурлаар хэлэлцэн дэмжигдэж үндэсний стандартаар баталлаа.

Энэхүү олон улсын стандартын шаардлагад нийцсэн Жуулчны мэдээллийн төвүүд байгуулагдсанаар Монгол Улсыг зорин ирж буй аялагч, жуулчид аяллаа төлөвлөх, шаардлагатай мэдээллийг найдвартай эх сурвалжаас авах, аяллын зорих газраа олох, аялал жуулчлалын байгууллагууд бүтээгдэхүүн, үйлчилгээгээ сурталчилах зэрэг нэгдсэн мэдээллийн платформ бий болж, ирэх жуулчдын тоо нэмэгдэх, аялал жуулчлалын салбарын хөгжилд ахиц гарах юм.

Жуулчны мэдээллийн төвд тавих шаардлагуудаас онцлон дурдвал:

- Үйлчилгээ үзүүлэх байршлыг жуулчид зорин очих хамгийн тохиромжтой газарт, жуулчдын зорчих замын дагуу байрласан байх
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хүртээмжтэй байх
- ISO 7001 стандартын шаардлагад нийцсэн тэмдэг тэмдэглэгээтэй байх
- Зочдод болон ажилтанд зориулсан өргөн цар хүрээг хамарсан мэдээллийн сантай,
- Аялал жуулчлалын үйлчилгээ эрхэлдэг төрийн болон хувийн хэвшлийн байгууллагын мэдээллийг ангилж хадгалдаг, түүнийг жил бүр шинэчилдэг байх
- Арилжааны үйл ажиллагаа эрхэлж буй Жуулчны мэдээллийн төв нь хууль тогтоомжийн зохих шаардлагад нийцсэн баримтжуулсан журамтай байх

Өнөөдрийн байдлаар Хөшигийн хөндийд баригдсан Чингис хаан Шинэ онгоцны буудалд тус стандартын дагуу Аялал жуулчлалын хөгжлийн төвөөс санаачлан Жуулчны мэдээллийн төвийг байгуулаад байна.

Аялал жуулчлалын стандартчиллын техникийн хорооны нарийн бичгийн дарга Г.Батзориг

ХҮНСНИЙ НОГООНЫ СТАНДАРТУУД ШИНЭЧЛЭГДЛЭЭ

Хүнсний аюулгүй байдал нь Үндэсний аюулгүй байдлын чухал хэсэг бөгөөд төрөөс баталсан хүнсний салбарын бодлого, авч буй арга хэмжээ түүний хэрэгжилтийг хангахад, хүнсний сүлжээний бүх үе шат дахь хүнсний чиглэлийн үйл ажиллагааны чанар аюулгүй байдлыг хангасан стандартууд зайлшгүй шаардлагатай билээ.

"Хүнсний тухай хуулийн 3.1.2-т "хүнсний аюулгүй байдал" гэж хүн ам амьдралынхаа туршид чанартай, шим тэжээллэг, аюулгүй хүнсийг улсын эдийн засаг, нийгмийн нөхцөл байдал, газар зүйн байршлаас үл хамааран тогтвортой, хүртээмжтэй сонгон хэрэглэх боломж бүрдсэн байх тухай тодорхойлсон.

НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага, Монгол Улсын Засгийн газар хамтран хэрэгжүүлсэн "Монгол Улсад ажлын байр нэмэгдүүлэх төсөл"-ийн дэмжлэгтэйгээр 2017 онд Монгол Улсын төмс, хүнсний ногооны савлагаа, шошгололт, хадгалалтын стандартын байдалд хийсэн дүн шинжилгээ, Стандартчиллын техник ажлын зарчмын дагуу 2018 онд үндэсний стандартын шинжлэх ухаан, техникийн түвшинд үзлэг хийсэн.

Эдгээр дүн шинжилгээ, үнэлгээний дүнд төмс, хүнсний ногооны стандартууд хуучирсан бөгөөд өнөөгийн хэрэглэгчид, тариаланчдын шаардлагыг хангахгүй байгаа гэсэн дүгнэлт гарсан.

Иймд "Монгол ногоо төсөл" нь 2018 оноос төмс, хүнсний ногооны стандартыг шинээр болон шинэчлэн боловсруулах ажлыг 11 зөвлөхийн бүрэлдэхүүнтэйгээр үе шаттайгаар зохион байгуулж ирсэн бөгөөд эхний ээлжинд боловсруулан батлуулсан хүнсний ногооны стандартуудыг үе шаттайгаар шинээр болон шинэчлэн боловсруулах ажлыг хийж байна. Өнөөдрийн байдлаар дор дурдсан стандартыг шинээр болон шинэчлэн боловсруулаад байна.

MNS 0255: 2020, Бөөрөнхий байцай. Техникийн ерөнхий шаардлага;

MNS 0257 : 2020, Цэцэгт болон мөчирт / брокколи/ байцай. Техникийн ерөнхий шаардлага;

MNS 0268 : 2020, Хүрэн болон шар манжин. Техникийн ерөнхий шаардлага;

MNS 0270 :2020, Шар лууван. Техникийн ерөнхий шаардлага;

MNS 0271 : 2020, Улаан лууван /тоором/. Техникийн ерөнхий шаардлага;

MNS 6881 : 2020, Бээжин байцай. Техникийн ерөнхий шаардлага;

MNS 6882 : 2020, Олон толгойт байцай / Брюссель/. Техникийн ерөнхий шаардлага;

MNS 6883 : 2020, Хятад байцай /тост байцай/. Техникийн ерөнхий шаардлага

MNS 6884 : 2020, Болцуут байцай /Кольраби/. Техникийн ерөнхий шаардлага

MNS 0256:2021, Хүнсний төмс. Техникийн ерөнхий шаардлага

Хүнсний ногооны стандартууд батлагдсанаар дараах ач холбогдолтой. Үүнд:

1. Хэрэглэгчид гарал үүсэл нь тодорхой, хүнсний аюулгүй байдлын шаардлага хангасан төмс, хүнсний ногоог хэрэглэх боломж бүрдэнэ.
2. Эх орны хөрсөнд ургуулсан төмс, хүнсний ногоог зэрэг, хэмжээгээр ангилан савлах, тээвэрлэхэд төдий хэмжээгээр энэ салбарт ажиллах хүчний тоо нэмэгдэнэ.
3. Мөн хүнсний ногооны агуулах, зоорь шинээр барих, тэдгээрт ажиллах боловсон хүчин, халдвар ариутгал хийх ажилтны ажлын байр бий болно.
4. Төмс, хүнсний ногоог савлах сав, баглаа боодлын үйлдвэрлэл хөгжинө.
5. Экспортод нийлүүлэхэд түлхэц болно.

СТҮБГ-ын ахлах мэргэжилтэн
Д.Даваасүрэн

“КЕЙТЕРИНГ ҮЙЛЧИЛГЭЭНД ТАВИХ ШААРДЛАГА” СТАНДАРТЫГ ХЭРЭГЖҮҮЛЖ ЭХЭЛЛЭЭ

“MNS 6885 : 2020, *Кейтеринг үйлчилгээнд тавих шаардлага”* стандартыг ХХААХҮЯ, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба, Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний салбарын зөвлөх төв, Монголын хоол үйлдвэрлэл, үйлчилгээний мэргэжлийн боловсролын академи нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг боловсруулж, СХЗГ-ын дэргэдэх Нийтийн хоолны стандартчиллын техникийн хорооны хурлаар хэлэлцэн дэмжсэн бөгөөд 2021 оны 01 дүгээр сарын 05-ны өдрөөс эхлэн хэрэгжүүлж эхэлсэн.

Энэхүү стандартад

- нэгдсэн зохион байгуулалттай арга хэмжээний үеэр захиалгат хоолыг хүргэх, түүгээр үйлчлэх
- захиалгат хоолыг хүргэх

гэсэн 2 төрлийн үйлчилгээ эрхлэгч, түүний үйлдвэрлэлийн байр, ажилтан, үйлчилгээ, аюулгүй байдалд тавих шаардлагыг тодорхой заасан.

Үүнээс гадна дэлхий нийтэд тархаад буй Короновируст халдвар (Covid-19)-ын цар тахлын нөхцөл байдалтай уялдуулан Нийтийн эрүүл мэндийн ноцтой байдал үүссэн үед хоол хүргэлтийн үйлчилгээг зохион байгуулахад захиалгат хоолыг хүргэх хүргэлтийн үйлчилгээнд тавих нэмэлт шаардлагыг тогтоосон онцлогтой, нэн чухал стандарт юм.

Мөн энэхүү стандартыг Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага болон Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүнс, Хөдөө Аж Ахуйн Байгууллагын хамтарсан Хүнсний хууль эрх зүйн хорооноос баталсан зохистой дадлын стандартууд, үүссэн нөхцөл байдалтай уялдуулан баталсан Олон Улсын Стандартчиллын Байгууллагаас батлан гаргасан стандарт, Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагаас гаргасан зөвлөмж болон Эрүүл мэндийн сайдын тушаалаар баталсан заавар зэрэг холбогдох стандарт, баримт бичигт тулгуурлан боловсруулсан болно.

СТҮБГ-ын ахлах мэргэжилтэн
Д.Даваасүрэн

APPLICATION



ЧИП БҮХИЙ ТӨЛБӨРИЙН КАРТ ЗАЙНААС УНШИХ БОЛОМЖТОЙ

Монголбанк нь Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн дагуу Монгол Улс дахь төлбөрийн системийг удирдан зохион байгуулах, хяналт тавих эрх, үүрэгтэй байдаг бөгөөд тус эрх, үүргийнхээ хүрээнд 2018 онд шийдвэр гаргаж Монгол Улсад ашиглагдаж буй үндэсний брэнд төлбөрийн ₮ картыг олон улсын шаардлага хангасан чип технологи руу шилжүүлэх ажлыг эхлүүлсэн. Энэхүү ажлыг олон улсын төлбөрийн картын үйл ажиллагаа эрхэлдэг МастерКарт байгууллагатай хамтарч хийж гүйцэтгэж буй бөгөөд, тус байгууллагын чип картын технологийг авч ашиглаж байна. Ингэхдээ тухайн чип дэх мэдээлэлд Монголбанкны таних дугаарыг суулгаж, өөрийн улсын онцлогт тохирсон бие даасан аппликейшныг чип рүү оруулах, улмаар аппликейшн эзэмшигчээр бүртгүүлэх шаардлага үүссэн.Үүнтэй холбоотойгоор Монголбанк нь Олон улсын стандартчиллын байгууллага болон Олон улсын цахилгаан техникийн комиссын Хамтарсан техникийн хорооны боловсруулсан ISO/IEC 7816-5 стандартын хүрээнд A000000843 бүхий бүртгэлийн дугаарыг 2020 оны 5 дугаар сард албан ёсоор хүлээн авч, тус олон улсын стандартыг ашиглаж эхэлсэн.

Монголбанкны зүгээс “Стандарт, хэмжил зүйн газар”-ын даргын тушаалаар батлагдсан “Гадаадын стандарт бүртгүүлэн хэрэглэх журам”-ын 2.1-д заасны дагуу холбогдох баримт бичгийг бүрдүүлж, 2020 оны 7 дугаар сард дээрх стандартыг бүртгүүлсэн бөгөөд тус олон улсын стандартыг үндэсний стандарт болгон батлуулах шаардлагын дагуу энэхүү танилцуулгыг бэлтгэлээ.

Энэхүү стандарт нь бүртгэлийн журам, түүнийг хариуцсан эрх бүхий байгууллага, аппликейшн эзэмшигчийг танихад ашиглагдах өгөгдлийн бүрэлдэхүүн хэсэг болон картын програмыг өөрийн нэрийн өмнөөс ашиглуулж буй этгээд гэсэн хэсгүүдээс бүрдэнэ.

Энэхүү стандартыг үйл ажиллагаандаа ашиглаж эхэлснээр МастерКарт байгууллагын чип технологи бүхий үндэсний брэнд төлбөрийн ₮ картыг зах зээлд нэвтрүүлэх, өөрийн улсын онцлогт тохирсон хөгжүүлэлтийг тус чип карт дээр суулгах, улмаар иргэдийн хэрэгцээ шаардлагад нийцэхүйц үндэсний төлбөрийн картын бүтээгдэхүүнийг бий болгох юм. Түүнчлэн, чип технологи нь соронзон тууз бүхий төлбөрийн картаас хэд хэдэн давуу талтай. Үүнд:

1. Картын мэдээллийг хуулбарлах, хуурамч карт үйлдэх боломжгүй;
2. Картын чип нь олон төрлийн функцийг дэмждэг тул нэмэлт аппликейшн суулгаж, олон төрлийн бүтээгдэхүүн үйлчилгээг нэг картаар авах боломжтой. /Жишээлбэл: нийтийн тээврийн картыг төлбөрийн картаар орлуулах, иргэний үнэмлэх, жолооны үнэмлэхийн мэдээллийг төлбөрийн картын чип рүү оруулах гэх мэт/;
3. Зайнаас төлбөр төлөх буюу заавал ПОС төхөөрөмж рүү картыг шургуулалгүй, 1-3 см-ын зайнаас уншуулах боломжтой.

Чип бүхий төлбөрийн карт зах зээлд нэвтэрснээр Монгол Улс дахь бэлэн бус төлбөрийн хэрэглээ нэмэгдэх, төлбөр тооцооны хурд, аюулгүй байдал нэмэгдэх, улмаар бэлэн мөнгөний хэрэглээ, зардал буурах, цаашилбал бэлэн мөнгөөр дамжих халдварт өвчин буурах гэх зэрэг өндөр ач холбогдолтой юм.

СТУБГ-ын мэргэжилтэн
Д.Төрмөнх

ҮСЧНИЙ ҮЙЛЧИЛГЭЭНД ТАВИХ НЭМЭЛТ ШААРДЛАГА

Өнөөдөр дэлхийн хэмжээнд Covid 19 цар тахал гарсантай холбоотойгоор эрүүл ахуй, ариун цэвэр, хөл хорионы дэглэм гэх мэт асуудал хурцаар тавигдаж байна. Ковидын нөхцал байдлын улмаас үйлчилгээний салбарт гарч байгаа стандартуудад ариун цэвэр, халдвар хамгаалалтын асуудлыг тусгах болсон.

Засгийн газрын 2018 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн 291-р тогтоолын хавсралт “Тохирлын баталгаанд заавал хамруулах бүтээгдэхүүн, үйлчилгээний жагсаалт”-ад үсчний үйлчилгээг хамруулсан байдаг. Цар тахлын үеийн зайлшгүй шаардлагаар “MNS 5160:2020, Үс засах үйлчилгээ”-ний стандартад : **“Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал, нийтийг хамарсан халдварт өвчин тархсан үед үс засах үйлчилгээ үзүүлэхэд тавих нэмэлт шаардлага”**-ыг оруулж шинэчилсэн нь цаг үеэ олсон ажил байлаа.

Нэмэлт шаардлагуудаас онцлон дурдвал:

- бүх эд зүйлсийг 2 цаг тутам халдваргүйжүүлэх, тогтмол агааржуулалттай байх, гар ариутгагч байршуулах,биеийн халуун үзэх
- суудал хоорондын зайг 2 метрээс доошгүй байлгах,

- урьдчилсан захиалгын дагуу үйлчилгээ үзүүлэх, үйлчлүүлэгч хүлээн авах боломжтой тохиолдолд захиалга авахдаа “Танхим чөлөөтэй тул Та үйлчилгээ авч болно” гэсэн зарлал байршуулж болно.
- Ажилтнуудын ариун цэвэр сахих нөхцлийг сайн бүрдүүлэх, сургалтад хамруулж амны хаалт зүүх шаардлагуудыг биелүүлэхэд хяналт тавих гэх мэт ажилтнуудад тавих цогц арга хэмжээ
- Тоног төхөөрөмж, багаж хэрэгсэлд тавих халдваргүйжүүлэх, ариутгах шаардлагуудыг мөн тусгасан байна.

Нийтлэг үйлчилгээний стандартчиллын ТХ-ны НБД Ш.Тэгшжаргал

“СТАНДАРТ, ХЭМЖИЛЗҮЙ” сэтгүүл

Монгол Шуудан ТӨХК-ний нэгдсэн захиалгад орлоо
Индекс: 200325